



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 771


Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг
чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Архивын ерөнхий газрын дарга асан С.Энхбаатар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Мэдээлэл технологийн хэлтсийн дарга асан Ж.Тамир нарыг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнээс 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ